



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Арилжааны цагийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Электрон арилжааны системийн арилжааны журам”-ын 14.2 дахь заалт, үнэт цаасын арилжаа, төлбөр тооцоо, хяналтын шинэ системд шилжиж байгаатай холбогдуулж “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны цагийн хуваарийг ажлын өдрүүдэд 10:00-13:00 цагийн хооронд явуулахаар шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолд нийцүүлэн холбогдох дүрэм, журамдаа зохих өөрчлөлтийг оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус даалгасугай.
3. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн, арилжааны цагийг сунгасан тухай олон нийтэд мэдээлж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001614